



НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар A/06

Улаанбаатар хот

Г Ажлын төлөвлөгөө, дуудлагын бүдүүвч батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 10 дугаар зарлиг, Монгол Улсын засгийн газрын 2020 оны 30, 39, 62, 63 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны тогтоол, шийдвэрүүд, Нийслэлийн Засаг даргын 2020 оны A/108, A/166, A/168, A/191 дүгээр захирамж, бусад шийдвэрүүдийг үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний гоц халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар Улсын Онцгой комиссоос гаргасан өндөржүүлсэн бэлэн байдлын болон хөл хорио тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, албан хаагчдад хүргэх дуудлагын бүдүүвч /схем-/ийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Шаардлага гарсан, онцгой тохиолдолд "Албан хаагчдад хүргэх дуудлагын схем"-ийн дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллахыг хариуцлагатай жижүүрт даалгасугай.

ЗАХИРАЛ



Б. БАЙГАЛМАА

Нийслэлийн Соёлын төв өргөөний
захирлын 2020 оны 10 дугаар сарын
10 өдрийн 10 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт


Хүний гоц халдварт өвчний үед хэрэгжүүлэх
ажил, арга хэмжээний төлөвлөгөө

Д/д	Хийх ажил	Хариуцах албан тушаалтан
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 10 дугаар зарлиг, Монгол Улсын засгийн газрын 2020 оны 30,39, 62, 63 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, албан хаагчдад танилцуулж, гоц халдварт өвчнөөс өөрийгөө, гэр бүлээ, хамаарал бүхий хүмүүсээ хамгаалах талаар заавар зөвлөгөө өгч, ажиллах	Захирал, албаны дарга нар
2	Албан хаагчдыг маск зүүлгэх, маск зүүгээгүй иргэнд үйлчлэхгүй байх, ажлын байранд нэвтрүүлэхгүй байх, жижүүр дээр ариутгалын бодисыг тогтмол хэрэглэх, ажлын байранд ариутгал, чийгтэй цэвэрлэгээг тогтмол хийж байх	албаны дарга нар
3	Архаг өвчтэй, ахмад настай, 0-12 настай болон жирэмсэн эмэгтэйчүүд, чихрийн өвчтэй ажилтнуудын ажлын цагийг богиносгох, цалинтай чөлөө олгох, гэрээр цахимаар ажил хийх боломж нөхцлийг бүрдүүлэх,	Захирал, албаны дарга нар
4	ЗГ, УОК, НЗД, НОК-оос гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх тусгай үүрэг /эргүүл/ гүйцэтгэж буй албан хаагчдын ажлыг зохицуулж, ажиллах нөхцлөөр хангаж өгөх,	Захирал, албаны дарга нар
5	Хөл хорио тогтоосон, өндөржүүлсэн бэлэн байдлын үед албан хаагчдад хүргэх дуудлагын схем, албан хаагчидтай холбоо барих утас, гэрийн хаяг бүхий дэлгэрэнгүй бүртгэлийг битүүмжлэн, хариуцлагатай жижүүрүүд хүлээнцэж, бэлэн байдлыг хангаж ажиллах	албаны дарга нар
6	Хөл хорио тогтоосон, өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажлын байранд гал гарах, ус алдах, дулааны шугамд гэмтэл үүсгэхгүй, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах,	албаны дарга нар

-----оо-----

Нийслэлийн Соёлын төв өргөөний
захирлын 2020 оны ... дугаар сарын
... өдрийн ... дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

Онцгой дэглэмийн үед албан хаагчдад
дуудлага хүргүүлэх бүдүүвч /схем/



-----oOo-----